



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991
Affiliated to FINA, 1996
Affiliated to AASF, 2000

2024 оны 09-р сарын 05-ны өдөр

№09

Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

МУССХ-ны “Гишүүнчлэлийн журам”-ыг
батлах тухай

“Монголын усан спорт сонирхогчдын холбоо” төрийн бус байгууллага (“Холбоо” гэх)-ын Удирдах зөвлөлийн хурлаас Холбооны дүрмийн 8.2-т “Гишүүнчлэлийн үндсэн шаардлага, гишүүн элсүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Удирдах зөвлөлийн хурлаар баталсан “Гишүүнчлэлийн журам”-аар зохицуулна” гэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

- Холбооны “Гишүүнчлэлийн журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
- Тус журмыг Холбооны бүх гишүүдэд сурталчлан таниулах, мөрдлөг болгон ажиллахыг Холбооны УЗ-ийн дэргэдэх зөвлөлүүд, гишүүн байгууллага, клубууд болон ЕНБД М.Энхбаатарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Батсаихан

П.БАТСАЙХАН



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү “Гишүүнчлэлийн журам” нь “Монголын усан спорт сонирхогчдын холбоо (цаашид МУССХ буюу Холбоо гэх)-ны дүрэм”-ийн 5, 6, 7 болон 8 дугаар зүйлд заасан МУССХ-ны гишүүний антилал, гишүүдийн эрх үүрэг, гишүүнээр элсэх болон гишүүнээс хасах, гишүүн клуб хооронд шилжих, гишүүн байгууллага клубууд нэгдэх, хүндэт гишүүнээр өргөмжлөх гэх мэт гишүүнчлэлтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулна.

“МУССХ-ны дүрэм” болон зорилгыг хүлээн зөвшөөрсөн усан спортын клуб, хувь хүн, хуулийн этгээд Холбооны гишүүн байж болно.

Гишүүн хуулийн этгээдийг Гишүүн клуб, гишүүн байгууллага гэж хоёр янзаар зэрэглэнэ.

Гишүүн хувь хүн гэж холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд, Удирдах зөвлөлийн дэргэдэх мэрэгжлийн зөвлөл, багийн гишүүд, тамирчин (насанд хүрээгүй бол эцэг, эх асран хамгаалагч нь төлөөлнө), шүүгч, дасгалжуулагч, дэмжигч зэрэг 18 насанд хүрсэн эрх зүйн чадамжтай хүн байна.

ХОЁР. МУУСХ-НЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНГИЛАЛ

2.1 Гишүүн клуб гэж усан спортын аль нэг, эсвэл түүнээс олон төрлөөр сургалтын болон тамирчин бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг хэлнэ.

2.2 Гишүүн байгууллага гэж олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын дэргэд усан спортын сургалт болон тамирчин бэлтгэх үйл ажиллагаагаа явуулдаг хуулийн этгээдийг хэлнэ.

2.3 Гишүүн хувь хүн нь:

- Тамирчин гишүүн (Насанд хүрээгүй тамирчныг түүний эцэг эх, эсвэл хууль ёсны асран хамгаалагч нь төлөөлнө)
- Шүүгч, дасгалжуулагч гишүүн
- Холбооны сонгогдсон, томилогдсон албан тушаалтан гишүүн
- Дэмжигч гишүүн
- Хүндэт гишүүн гэсэн ангилалтай байна.



2.4 Гишүүн нь МУССХ-ны дүрэм, зорилгыг хүлээн зөвшөөрсөн, 18 нас хүрсэн эрх зүйн чадамжтай хүн байна.

ГУРАВ. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ШААРДЛАГА

- 3.1 Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж байх
- 3.2 МУССХ-ны дүрэм болон бусад дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх
- 3.3 Холбогдох гишүүнчлэлийн татварыг тогтоосон хугацаанд төлсөн байх
- 3.4 Холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцож, усан спортын нэр хүндийг ямагт эрхэмлэн дээдлэх

ДӨРӨВ. ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

- 4.1 Холбооны гишүүн нь холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрмийг удирдлага болгон ажиллана.
- 4.2 Холбооны дүрэм, Удирдах зөвлөлөөс баталсан журмуудыг чанд сахиж, холбооны үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцож, гишүүний татварыг энэ дүрэмд заасан хугацаанд бүрэн төлнө.
- 4.3 Гишүүн нь Монгол улсын усан спортын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах, аливаа санал, санаачлага гаргах, өөрийн болон гадаад орнуудад усан спортыг хөгжүүлж буй туршлагыг судалж бүтээлчээр хэрэгжүүлнэ.
- 4.4 Ёс зүйн болон санхүүгийн зөрчил, холбооны дүрэмд харш үйлдэл гаргахгүй байх
- 4.5 Тамирчин гишүүн дотоод гадаадын уралдаан тэмцээнд оролцох болвол зохих бэлтгэл сургуулитыг хийж, хамт олон, улсыг төлөөлөн нөөц боломжоо дээд хэмжээнд дайчлах
- 4.6 Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг биелүүлэх
- 4.7 Гишүүн нь Монгол улсыг төлөөлөн уралдаан тэмцээнд оролцохдоо багийн ахлагчийн удирдлага, зохион байгуулалт доор бүхий л үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй

ТАВ. ГИШҮҮНИЙ ЭРХ

- 5.1 Гишүүн нь Холбооны бүх шатны байгууллагад сонгох, сонгогдох.



- 5.2 Холбоо болон усан спортын тухай аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд ажил хэрэгчээр идэвхтэй оролцох.
- 5.3 Дотоод, гадаадын тэмцээн уралдаан бусад арга хэмжээнд өөрийн байгууллага хамт олон, эх орноо төлөөлж, зохих бэлтгэлтэйгээр оролцох.
- 5.4 Бассейн буюу танхим, спортын хувцас форм, хэрэглэл, материал, тоног төхөөрөмжийг тогтоосон журмын дагуу ашиглах
- 5.5 Өөрийн орны болон дэлхийн усан спортын үйл явдал, технологийн дэвшилд суурисан өөрчлөлтийн талаарх мэдээллийг холбоогоор дамжуулан түгээх
- 5.6 Үр бүтээлтэй ажиллаж, спортын өндөр амжилт гаргасныхаа төлөө материалын болон сэтгэл санаа, нэр хүндийн урамшуулал хүртэх
- 5.7 Холбооны гишүүн байгууллага нь Холбооноос зохион байгуулж байгаа уралдаан тэмцээнд оролцохдоо тухайн тэмцээний удирдамжаар тогтоосон оролцох эрхийн хураамж төлөхгүй байх. (Үүнд тамирчдын гарааны хураамж болон гишүүний татвар хамаarahгүй)
- 5.8 Гадаад, дотоодод зохион байгуулагдах олон улсын сургалт, семинар, уулзалтын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авах, оролцох
- 5.9 Холбооны үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, гишүүдийн эрх ашгийг хамгаалах асуудлаар мэдээлэл авах, санал, зөвлөгөө өгөх, шаардлага хүргүүлэх, журам санаачлан боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах, гишүүний татвар, хураамж болон түүний зарцуулалтын талаархи мэдээллийг авах, санхүүгийн үйл ажиллагааны тайлантай танилцах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.
- 5.10 Холбооны албан ёсны вэб хуудас болон нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглан үйл ажиллагаагаа сурталчилах эрхтэй

ЗУРГАА. ГИШҮҮНИЙ ТАТВАР

6.1 Гишүүн нь тогтоосон татварыг жил бүрийн 3 сарын 31-ний дотор холбооны дансанд тушаасан байна. Хүндэт гишүүн энэхүү татвараас чөлөөлөгднө.

6.2 Гишүүнчлэлийн татварын хэмжээг Удирдах зөвлөл тогтооно. Гишүүнчлэлийн татвар нь жилийн:

а. Гишүүн клуб -	500,000 төг
б. Гишүүн байгууллага -	300,000 төг
в. Ерөнхийлөгч-	10,000,000 төг
г. Дэд Ерөнхийлөгч-	500,000 төг
д. Удирдах зөвлөлийн гишүүн-	200,000 төг



е. Хяналтын зөвлөлийн гишүүн-	50,000 төг
ё. Зөвлөл, багийн гишүүн	50,000 төг
ж. Тамирчин, дасгалжуулагч, шүүгч, дэмжигч гишүүн	50,000 төг
з. Хүндэт гишүүн-	Татвар төлөхгүй

хэмжээтэй байна.

6.3 Татварыг жил бүр эсвэл дөрөв хүртэл жилээр бөөнд нь төлж болно.

6.4 Холбооны гишүүн байгууллага, клубт харьялагддаг хувь гишүүний татварыг тухайн байгууллага/клуб нь нэгтгэн хурааж холбооны дансанд шилжүүлнэ.

ДОЛОО. ХҮНДЭТ ГИШҮҮН

7.1 Хүндэт гишүүн нь холбооны үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд үлэмж хэмжээний хувь нэмэр оруулсан нэгэн байх бөгөөд Удирдах зөвлөлийн дэргэдэх зөвлөл эсвэл ЕНБД санал оруулж Удирдах зөвлөлийн хурлаар батална.

7.2 Нэг удаа 10.000.000 (арван сая) болон түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хүнийг Хүндэт гишүүнээр батална.

7.3 Гишүүний төлсөн татварыг хандивт тооцохгүй.

7.4 Монгол улсын хууль тогтоомжийн дагуу ял шийтгэл эдэлсэн, Холбооны Ёс зүйн зөвлөлийн шийдвэрээр шийтгүүлж байсан, сэргээшийн асуудлаар шалгагдаж байгаа эсвэл шийтгүүлж байсан этгээд хандив өгч болох боловч Хүндэт гишүүн болох боломжгүй.

7.5 Хүндэт гишүүн энэхүү журмын 7.4-т заасан шийтгэлүүдийн аль нэгийг хүлээвэл Удирдах зөвлөлийн шийдвэрээр Хүндэт гишүүнээс хугацаагүйгээр түтгэлзүүлэх бөгөөд хэрэв 7.2-т заасан хандивыг буцаан олгохгүй.

7.6 Хүндэт гишүүн холбооны хувь гишүүний татвар, хураамжаас чөлөөлөгдөнө. Үүнд: хувь гишүүний татвар, тэмцээний гарaanы хураамж гэх мэт.

7.7 Хүндэт гишүүн нь Их хуралд оролцож төлөөлөгчийн саналын таслах эрхээс бусад эрхийг эдэлнэ.

7.8 Хүндэт гишүүний Их хуралд оролцох эрх Хүндэт гишүүнээр батлагдснаас хойш нэг жил өнгөрсний дараа нээгдэнэ.

НАЙМ. ГИШҮҮНИЙ ХАРЬЯАЛАЛ, ХАРЬЯАЛАЛ ШИЛЖИХ

8.1 Тамирчны гишүүн клуб, байгууллагатай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол тамирчин харьяалалаа өөрчлөх боломжтой. Ямар ч тохиолдолд холбооны



гишүүн клуб, байгууллагууд тамирчдын шилжилтыг хориглосон хатуу заалтыг тамирчинтай байгуулах гэрээнд тусгахыг хориглоно.

8.2 Тамирчин харьяалалаа өөрчилсөн талаархи мэдэгдлийг ЕНБД-д бичгээр (эсвэл цахим шуудангаар) мэдэгдсэн өдрөөс хойш 1 сарын хугацаа өнгөрсний дараа шинэ клуб, байгууллагаа төлөөлөн тэмцээн, уралдаанд оролцох эрх нь нээгдэнэ.

8.3 Холбооны гишүүн клуб, байгууллага нь тамирчны шилжилтээс үүдэн санхүүгийн хохирол амссан гэж үзэж байгаа бол энэхүү асуудлаа тамирчинтай байгуулсан гэрээнийхээ хүрээнд шийдвэрлэх үүрэгтэй.

8.4 Гишүүн байгууллага, клубууд нэгдэж нэг клуб, байгууллага болж болно. Энэхүү нэгдсэн талаархи мэдэгдлийг ЕНБД-д бичгээр (эсвэл цахим шуудангаар) мэдэгдсэн өдрөөс хойш 1 сарын хугацаа өнгөрсний дараа тухайн нэгдсэн байгууллага, клуб тэмцээн, уралдаанд оролцох эрх нь нээгдэнэ.

8.5 Гишүүн байгууллага, клубууд зөвхөн тэмцээн уралдаанд оролцохын тулд түр хугацаагаар нэгдэж болох бөгөөд энэ тухай тэмцээн болохоос дор хаяж 3 сарын өмнө ЕНБД-д бичгээр мэдэгдсэн байна.

ЕС. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ, ГИШҮҮНЧЛЭЛИЙГ ТҮТГЭЛЗҮҮЛЭХ, ХАСАХ

9.1 Холбооны гишүүнээр элсэхийг хүссэн байгууллага, клуб нь ЕНБД-д хүсэлтээ бичгээр гаргаж шийдвэрлүүлэх бол хувь хүн нь гишүүнчлэлийн татвараа төлснөөр гишүүнээр элссэнд тооцно.

9.2 Хувь гишүүн бүртгэлээ Холбооны вэб хуудсаар дамжуулан хийх бөгөөд ЕНБД бүртгэлийг баталгаажуулснаар вэб хуудсанд гишүүний мэдээлэл байршина. /Хавсралт 1/

9.3 Гишүүн байгууллага, клубын бүргэлийг маягтын дагуу хүлээн авч ЕНБД холбооны вэб хуудсанд мэдээллийг байршуулна /Хавсралт 2/.

9.4 Гишүүний гишүүнээр элссэн огнооноос үл хамааран дараа оны 3 сарын 31-ний дотор татвараа төлөөгүй бол гишүүний эрх дуусгавар болно.

9.5 Дараах үндэслэлээр гишүүнийг гишүүнээс хасна. Үүнд:

9.5.1 Холбооны эрхэм зорилго, үндсэн дүрэм болон бусад дүрэм журмыг удаа дараа эсвэл ноцтой зөрчсөн, холбооны нэр хүндэд хохирол учруулсан, Ёс зүйн дүрмийг зөрчиж энэ нь Ёс зүйн зөвлөлийн шийдвэрээр баталгаажсан бол

9.5.2 Усан спортын нэр хүндэд харш үйлдэл хийсэн бол

9.6 Гишүүн байгууллага, клубыг гишүүнээс хасах асуудлыг Ёс зүйн зөвлөлийн саналыг үндэслэн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд тухайн гишүүн байгууллага клубын удирдлагад урьдчилан бичгээр мэдэгдэж, асуудлыг хэлэлцэх хуралд биеэр оролцон тайлбар өгөх боломжоор хангана.



9.7 Гишүүн хувь хүнийг гишүүнээс хасах шийдвэрийг Холбооны Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд тухайн гишүүнд урьдчилан бичгээр мэдэгдэж, асуудлыг хэлэлцэх хуралд биеэр оролцон тайлбар өгөх боломжоор хангана.

9.8 Гишүүн гишүүнчлэлээсээ хасагдсан тохиолдолд холбооны бүхий л үйл ажиллагаанд оролцох эрх нь дуусах бөгөөд энэ нь түүний буруутай үйлдлийн улмаас бусдад учруулсан бодит хохирлыг барагдуулах хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.9 Гишүүнчлэлээс хасагдсан тохиолдолд гишүүний татвар, хураамж болон бусад мөнгөн хандивыг эргүүлэн олгохгүй.

АРАВ. БУСАД

10.1 Гишүүн клуб, байгууллага болон хувь гишүүний мэдээллийг Холбооны албан ёсны вэб хуудсанд гишүүний зөвшөөрснөөр байрлуулна.

10.2 Гишүүн хувь хүн нь гишүүнчлэлийн үнэмлэх, энгэрийн тэмдэгтэй, байгууллага болон клуб нь гэрчилгээтэй байна.

10.3 Холбоо нь бүх гишүүддээ эрх тэгш үйлчлэх бөгөөд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

МУССХ-ны УЗ-ийн 2024 оны 09-р сарын 05-ны өдрийн №09 тоот тогтолцойн Хавсралт
Гишүүнчлэлийн журам



МУССХ-НЫ ХУВЬ ГИШҮҮНИЙ БҮРТГЭЛ /Хавсралт 1/

№	Асуумж
1.	Овог, нэр
2.	Сонгох /Тамирчин, Дасгалжуулагч, Шүүгч, Бусад/
3.	Цээж зураг /оруулах/
4.	Клубын харьяалал
5.	Төрсөн он/сар/өдөр
6.	Хүйс /сонгох/
7.	Ажил, сургууль
8.	Утас
9.	И-мэйл хаяг

МУССХ-ны УЗ-ийн 2024 оны 09-р сарын 05-ны өдрийн №09 тоот тогтоолын Хавсралт
Гишүүнчлэлийн журам



МУССХ-НЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, КЛУБЫН БҮРТГЭЛ /Хавсралт 2/

№	Асуумж
1.	Гишүүн байгууллага, клубын нэр
2.	Байгууллага клубын таних тэмдэг, лого
3.	Байгуулагдсан он
4.	Байршил
5.	Удирдлагын овог нэр
6.	Холбоо барих утасны дугаар
7.	И-мэйл хаяг
8.	Вэб хуудас
9.	Дасгалжуулагчдын тоо
10.	Тамирчдын тоо
